

БАТЛАВ.
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ТӨМӨРБААТАР

Д. Төмөрбаатар
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙ
БОЛОН ГЭР ХОРООЛОЛ, ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЙ ДОТОРХ ЗАМ ТАЛБАЙН
ӨДӨР ТУТМЫН ЦЭВЭРЛЭГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

№

Улаанбаатар хот

Захиалагч байгууллага	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
Зорилго	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай болон гэр хороолол, орон сууцны хороолол доторх зам талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж үнэлэх, дүгнэх, зөвлөмж өгөх
Хугацаа	Захиалагч болон зөвлөхийн хооронд байгуулах гэрээнд хугацааг тодорхой тусгах бөгөөд гэрээнд заасан төлбөрт багтаан Зөвлөх үйлчилгээг үзүүлнэ. Захиалагч болон Зөвлөхийн хооронд байгуулсан гэрээнд заасан хугацаагаар Зөвлөх үйлчилгээний ажил эхэлж, гүйцэтгэлийн тайланг хүлээлгэн өгсөнөөр ажил дуусгавар болно.
Ажлын хамрах хүрээ	<p>Зөвлөх нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Зам талбайн байгууллагуудын гэрээний үүргийн биелэлтийн гүйцэтгэл Замын зорчих хэсгийн талбайн цэвэрлэгээ Замын нуухны цэвэрлэгээ Цэвэрлэгээнээс гарсан хог ачилт Автобусны буудлын хогийн сав суллалт Автобусны буудлын зогсоолын цэвэрлэгээ Хальтиргаа гулгаанд арга хэмжээ авсан байдал Зам талбайн цэвэрлэгээнд машин механизм, техник ажиллуулсан байдал Явган замын цэвэрлэгээ Хананаас хана хүртэлх цэвэрлэгээ, түүвэр хогны цэвэрлэгээ Гэрлийн шон, хашиа, ханан дээрх сурталчилгааны хуудас цэвэрлэсэн байдал Зам талбайн цэвэрлэгээний байгууллагуудын хариуцсан гудамжнуудын шарилж лууль цэвэрлэсэн байдал Батлагдсан норм, норматив болон гэрээний нөхцөл, Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журамын зам талбай цэвэрлэх журмын хэрэгжилтэнд хяналт тавих Зам талбайн цэвэрлэгээний байгууллагуудын хариуцсан гудамж талбайн хайс, хашилага угаасан байдал Дүүргийн гудамж талбайд гарсан зөрчлийг илрүүлж, акт тогтоож, захиалагч байгууллагад хүргүүлэх Гэрээт ААНБ-уудын сар бүрийн ажлын гүйцэтгэлийг хянан дүгнэх, захиалагч байгууллагад хүргүүлэх

	<p>17. Захиалагчаас зарласан цаг үеийн шаардлагатай хуралд оролцох, тайлан танилцуулга бэлтгэх</p> <p>18. Захиалагчид улирал бүр хийсэн ажлын танилцуулгыг бэлтгэж танилцуулах</p> <p>19. Талбайд ажиллаж байгаа аж ахуйн нэгж болон ажилчдын ажлын байрны анхан шатны зааварчилгаа авч ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих</p>
Зөвлөхөд тавигдах шаардлага	<p>Зөвлөхөд дараах шаардлага тавигдана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн чиглэлээр сүүлийн жил 2020-2024 онуудад ижил төстэй зөвлөх үйлчилгээ үзүүлсэн сүүлийн 3-5 жилийн ажлын туршлагатай байх нь давуу тал болно. - Хог хаягдлын менежмэнтийн чиглэлээр гэрчилгээтэй сургалтанд хамрагдсан байх - Хог хаягдлын салбарт 6-с доошгүй жил ажилласан байх <p>Зөвлөх баг дараах бүрэлдэхүүнтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хяналт шинжилгээ үнэлгээний ажилтан (2-оос доошгүй жил судалгаа шинжилгээ хийсэн байх) - Хог хаягдлын тээвэрлэлт, зам талбайн цэвэрлэгээ арчилгааны ажлын чиглэлээр дотоодын компаниудад зөвлөгөө өгч хяналт мониторинг хийж сүүлийн 4 жилд хамтран ажиллаж байсан туршлагатай байх - Хяналтын ажилтан нь Хог хаягдлын менежмэнтийн чиглэлээр гэрчилгээтэй сургалтанд хамрагдсан байх - Зөвлөгөө өгөх багаар ажиллах чадвартай
Үр дүнг тайлагнах	Зөвлөх үйлчилгээг үзүүлэх зөвлөх нь Захиалагчаас өгөх чиглэл, зааврын дагуу ажиллана.

ХЯНАСАН:

АГААРЫН БОХИРДЛОТЙ ТЭМЦЭХ ТАСГИЙН ДАРГА *Ж.НЯМХҮҮ* Ж.НЯМХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:

ОРЧНЫ БОХИРДОЛ,
ХОГ ХАЯГДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ш.БАТПУРЭВ